



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 07304

Улаанбаатар хот

Шалгалтын нислэгт тавигдах шаардлагад  
өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, ИНД-171 "Агаарын навигацгийн үйлчилгээний техникийн байгууллага үйл ажиллагаа ба гэрчилгээжүүлэлт"-ийн 171.59 (д) заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2017 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн А/176 дугаар тушаалаар өөрчлөн батлагдсан "Шалгалтын нислэгт тавигдах шаардлага"-ын 12 дугаар зүйлийн (в) хэсгийн "DVOR approach-24 сар хүртэл" гэснийг "DVOR approach-36 сар хүртэл" "a-DVOR байгууламжийг хүлээн авах шалгалтын нислэг болон ээлжит шалгалтын нислэгийг гүйцэтгэсний дараа "ICAO Doc 8071 Vol 1 Manual of testing radio navigation aid Chapter 2" -ын "Maintenance activities that require flight inspection" заалтын 2.2.38-д тусгайлан заасан засвар, үйлчилгээг хийгээгүй тохиолдолд" болгон тус тус өөрчилсүгэй.

2. Шалгалтын нислэгт тавигдах шаардлагуудын дагуу үйл ажиллагааны зааварт зохих өөрчлөлт оруулахыг Нислэгийн журам боловсруулалтын алба /Г.Түвшинбаяр/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба /С.Манлай/-нд тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН